



Шинжээчийн багийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургууль

Хөтөлбөрийн нэр: График дизайн

Индекс: 021106 бакалавр

Шинжээчийн баг:

Ахлагч: М. Моломжамц	Монгол улсын боловсролын их сургууль, Дүрслэх урлаг, технологийн сургуулийн Дизайны тэнхимийн дэд профессор, доктор
Гишүүд: Б. Оюунсүрэн	Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Бизнесийн удирдлагын тэнхимийн дэд профессор, доктор
М.Амартүвшин	Соёл урлагийн их сургуулийн Сургалт, цахим шилжилтийн газрын дарга

Он сар өдөр: 2023-3-15

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нартай хийх уулзалт

II. Оюутан, суралцагчидтай хийх уулзалт

III. Ажил олгогчидтой хийх уулзалт

IV. Төгсөгчидтэй хийх уулзалт

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	График дизайн бакалавр	
Индекс	021106	
Шинжээчид	1. Ахлагч: М.Моломжамц 2. Гишүүн: Б.Оюунсүрэн 3. Гишүүн: М.Амартүвшин	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Ж.Мөнхбилэг - БМИҮЗ-ийн магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу
	2023.02.01	Шинжээчийн багийг томилох
	2023.02.01	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	2023.02.03	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	2023.02.10	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2023.02.14-15	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	2022.12.21	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2023.02.27	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	2023.02.27	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2023.02.28	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
		Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Түүхэн товчоон: Улс орныг үйлдвэржүүлэх, үндэсний үйлдвэрлэл, соёл үйлчилгээг хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, сэтгэлийн таашаалд тохирсон соёлтой үйлчилгээ явуулах, ажил амьдралын таатай орчин бүрдүүлэх хэрэгсэл болсон дизайн урлагийг нийгмийн амьдралын бүх хүрээнд хөгжүүлэн төлөвшүүлэх зорилгоор 1994-1995 оны хичээлийн жилд ШУТИС-ийн “ХҮНДЭТ ПРОФЕССОР” Ц.Дагвадорж агсаны санаачилга, шууд оролцоотойгоор ТИС-ийн БИС-ийн Инженерийн зураг зүйн тэнхимийн дэргэд Үйлдвэрлэлийн дизайны тэнхимийн эх суурь тавигдаж бакалавр, магистрын зэрэглэлтэй дизайнер бэлтгэж эхэлсэн түүхтэй. Салбарын эрхлэгч-1, профессор-1, дэд профессор-2, ахлах багш -13, багш-10, сургалтын мастер-3 гэсэн бүрэлдэхүүнтэйгээр сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна.

–

Мэргэжлийн онцлог

График дизайны хөтөлбөрийн дагуу дизайны үндсэн мэдлэг, зураглах ур чадвар эзэмшин график дизайны мэргэжлээр гүнзгийрүүлэн суралцах болно. График дизайны төгсөгч нь орон зайн бүтээлч сэтгэхүйгээ хөгжүүлснээр гурван хэмжээст загвар, дүр бүтээх, хөдөлгөөнт график, анимаци хийх ур чадвартай болж телевиз, студи, компаниудад дизайнерын мэргэжлээр ажиллана.

Эзэмших мэдлэг

Тухайн мэргэжлээрээ амжилттай суралцаж төгссөн оюутан нь дизайны мэргэжлийн өндөр ур чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй, судлах, зурах, зохиомжлох үндсэн техник ба технологийн мэдлэгт суралцаж мэдлэгээ хөгжүүлэн шинэ санаа гаргаж зургийн хэлбэрээр илэрхийлж сурсан, өрсөлдөх чадвартай, график дизайны мэргэжлийн дагуу судалгаа гүйцэтгэх, загварчлах арга зүйн мэдлэг, ур чадвар, өөрийн зохиомжилсон эскиз загваруудаас сонголт хийж учир шалтгааныг тайлбарлан бүтээлийн санаа гаргаж загварчлах мэргэжлийн сэтгэлгээ эзэмшинэ.

Эзэмших ур чадвар

Тухайн мэргэжлээр амжилттай суралцаж төгссөн оюутан нь зураглах, загварчлах, төлөвлөгөөг томъёолох хүрээнд ажлын дэс дарааллын шаардлагыг тодорхойлох, өмнөх ажил дээрх ялгааг харьцуулах, судлах, шийдлүүдийг дахин хянах, ашиглах, төслийн зорилго болон судалгааны ажлын боловсруулалт дээр суурилсан төгсгөлийн загварыг сонгох ур чадваруудыг, мэргэжлийн чадамж хувийн зан чанарын хувьд зорилго болон ажлын агуулгыг шинжлэх, тодорхойлох, шийдвэрлэх, багаар ажиллах, бусдыг хүлээн зөвшөөрөх, зорилгод хүрэх, манлайлах, харилцааны үндсэн зарчмыг ашиглан илтгэлд санаагаа зөв илэрхийлэх ур чадваруудыг, мэргэжлийн ур чадвар болон хандлагын хувьд тулгарсан асуудалд ёс зүйтэй хандах, шийдвэр гаргах, орчин үеийн шинэ техник технологи, програм хангамжийг ашиглах, шинжлэх, ёс зүй, үнэт зүйлсийг эрхэмлэх ур чадваруудыг эзэмшинэ.

Ажлын байр

График дизайн мэргэжлээр суралцсанаар телевизийн салбар, студи болон хувийн салбарт ажиллах боломжтой бөгөөд тусгай мэргэжлийн сургуулиудад зохих сурганы модуль төгссөний дараа багшилж болно.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч, сонирхогч, төгсөгч, суралцагч талуудын хүсэл сонирхолд нийцсэн, нийгмийн хэрэгцээ шаардлага хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулж шинэчилдэг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Тайланд байгаа STEEP шинжилгээний үзүүлэлт нь тухайн мэргэжлийн хэрэгцээг дагаж хөтөлбөрийн шаардлага байгааг тусгасан байна.
- Алсын хараа 2050-д бүтээлч үйлдвэрлэлийн салбарын хөгжил, Монгол улсын ЗГ-ийн Дижитал Монгол хөтөлбөр зэрэг тайланд оновчтой тусгасан зүйлс байна.
- Алсын хараа – 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр, сургалтаа соёлын өв, эх хэл, эх түүх, өв соёлоо нийт хүн амд төлөвшүүлэх улсын бодлогын тодорхойлох заалтанд хамруулсан байна.
- Дүрслэх урлагийн чадвар, компьютерийн технологийн хөгжлийн дундаас нэгдэн гарч ирсэн эрэлт хэрэгцээн дээр тулгуурлан ажиллаж байгаа хөтөлбөр юм.
- Хөтөлбөр нь суралцагчдаас олон талын мэдлэг, чадвар, мэргэжлийн болон хувь хүний харилцаа хандлага талаас давуу талыг бүрдүүлсэн байна. Энэ талын хэрэглээ шаардлагыг төгсөгчидтэй хийсэн уулзалтаар нотлох баримт болно.
- Хөтөлбөрийн төлөвлөлтөнд дизайны мэргэжлийн өндөр ур чадвар, бүтээлч сэтгэлгээ, загварчлах, судлаач арга зүй, зурах, зохиомжлох, техник технологийн мэдлэгт суралцаж нийгмийн шаардлага хангасан боловсон хүчин бэлтгэх чадвартай хөтөлбөр гэж болно.
- Суралцагчидтай хийсэн уулзалтанд оюутнуудын саналд суралцагч хөтөлбөртөө сэтгэл ханамж, багшлах боловсон хүчний харилцаа хандлага сайн байдаг талаар төгсөгч, суралцаж байгаа оюутнууд санал нэг хэлж байлаа.
- Дизайны сургалтын хөтөлбөрийг үзэж төгссөнөөр урлагийн шийдэл, бизнес, гадаад орчин, нийгмийн хэрэглээнд тогтвортой хөгжлийг хангасан алсын хараа ур чадвартай байна.

Онцлог зүйл: /давуу тал, сайн туршлага гэх мэт/

- Монгол улсын дизайны салбарт тогтвортой хөгжлийн бодлогод чавдварлаг мэргэжилтэн бэлтгэх зорилгоо биелүүлэх боломжийг харуулсан байна. Хөтөлбөрөөр эзэмших ур чавдарт PLO, CLO уялдааг хангасан байгаа нь тайланд тусгагдсан байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын орчинг шинээр төлөвлөсөн нь хамт олны нэг чиг хандлага бөгөөд хэрэгжүүлэх шатны шийдвэр хэрэгтэйг харуулж байна.
- Сургалт сайн явж байгаа ч гэсэн орчин шаардлагад нийцэх үзүүлэлтээр хангалтгүй муу байна.

Дүгнэлт: /үнэлгээ өгөх үндэслэл/

- Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагад тавигдсан нөхцөлд мэргэжлийн хичээлүүдийн зарим хэлбэр нь сургалтанд амжилттай явуулах боломж өгсөн гэж болно. Уран зураг, хар зураг, хээрийн дадлагын явуулах хэлбэр нь суралцагч оюутнуудыг хөгжүүлэх хамгийн нээлттэй хэсэг болтол хэлбэржсэн байна. Хөтөлбөрөөр дамжуулан хөгжүүлж байгаа мэргэжлийн хичээлүүдийг сургалтанд чадварлаг заах боломжоор бүрдүүлж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн нийгмийн эрэлт хэрэгцээг гадаад, дотоод ижил мэргэжлийн хөтөлбөрүүдтэй харьцуулсан үр дүнг хэрхэн үнэлж, хөтөлбөрийг өөрчлөн сайжруулсан талаар тайланг бэлтгэдэг байх.
- Хөтөлбөрийн шинэчлэлд баримталж буй үр дүнд суурилсан боловсролын арга зүйн хэрэглээ, График дизайнер хүний эзэмшсэн байх мэдлэг, ур чадварын үндсэн 4 үзүүлэлт тус бүр дээр үнэлгээ, дүгнэлт өгч, хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлдэг байх.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх материаллаг орчин нөхцөлийг сайжруулах.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Бие хүнийг бүтээлч, хариуцлагатай, мэргэжлийн ёс зүйтэй болгож төлөвшүүлэх, нийгэмшил, харилцааны ур чадваруудыг олгож байгаа нь багш оюутнуудын нэг чиг хандлагаас харагдаж байна.
- Инновацид тулгуурласан сургалт, судалгаа, туршилтын чанартай үйлчилгээ үзүүлэх алсын хараагаа төлөвлөсөн байна.
- Бүтээлч сэтгэлгээтэй өрсөлдөх чадвартай, төлөвшсөн, хариуцлагатай мэргэжилтэн судлаачдыг бэлтгэх зорилго хөтөлбөрт тусгасан гэж үзэж байна. Мэргэжлийн уран бүтээлд чадамж, мэдрэмж, сэтгэлгээ сайтай төгсөгч гаргах боломж хөтөлбөрт тусгагдсан байна.
- Хувь хүний хандлага, байнга тасралтгүй хөгжих, харилцааны ур чадвар, багаар ажиллах, ёс зүйтэй байх, төлөвлөх чадвар, гадаад хэлээр харилцах чадвар зэргийг хөтөлбөрийн уялдаа холбоотой байна.

Онцлог зүйл:

- Үйлдвэрлэл, бизнесийн хүрээнд амжилттай ажиллах цогц чадвар төгсөгч, суралцагчдад төлөвшсөн байгаа нь төгсөгч, ажил олгогчдын уулзалт, нотлох баримтаар батлагдсан.

Анхаарах асуудал:

- Элсэлтийн журам шинэчлэгдэлгүй удсан нь авьяас чадвартай оюутнуудыг элсүүлэх боломж хумигдаж байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч баг хамт олны саналыг тусгалгүй хөтөлбөрийн нэр, сургууль, тэнхимийн нэр өөрчлөгдөж байгаа нь элсэлтэнд сөргөөр нөлөөлж байна.

Дүгнэлт:

- Хөтөлбөрийн зорилго нь нийгмийн шаардлагыг хангах талаасаа боловсрол олгох, мэргэжлийн ур чадварын үнэлгээг сайн хэрэгжүүлж байна. Төгсөгчдийн уулзалтын үеэр тэдний мэргэжлийн ур чадвар ажил ологчоос тавигдах шаардлагад нийцэж байгаагаа өөрийн үнэлгээгээр харьцуулж ярилцсан байна. Тус мэргэжлийн төгсөгчдийн хөтөлбөрт хандах сэтгэл ханамж сайн байсан бөгөөд зарим нэг мэргэжлийн хичээлүүдийн цагийн багтаамжийг эргэж харах талаар сэтгэгдлээ хэлсэн.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Элсэлтийн журмаа шинэчлэн сайжруулахад анхаарч, авьяас чадвартай оюутнуудыг элсүүлэх боломжийг нэмэгдүүлэх.
- Хөтөлбөрийн зорилгоо ямар үндэслэлээр дэвшүүлсэн, хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлсэн болон батлуулсан талаар баримт бичгийг бэлддэг байх.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн 2014 оны 021202 график дизайн хөтөлбөрийн баримт бичгийг Хөтөлбөрийн салбар хороо 2014.04 сар, Ерөнхий хороо 2014.05 сар, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлөөр 2016.06.27-нд тус бүр хэлэлцэж, сайжруулсан.
- Сургалтын хөтөлбөрийн гол шинэчилсэн хэсэг бол мэргэжлийн ур чадвар, хувь хүний харилцаа хандлагыг сайжруулахад чиглэсэн байна.
- Оюутнуудыг монгол уламжлалт нүдний ур, ухааны ур, гарын ур гэсэн цогц мэдрэмжээр хөгжүүлэх боломжтой хөтөлбөр байна.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явцад ашиглаж буй сургалтын агуулга, арга зүй нь хөтөлбөрийн хүрэх үр дүнд хэрхэн нөлөөлсөн нь нотлох баримт материалуудаас харагдаж байсан.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шалгуур, шаардлага нь хөтөлбөрөөр төгсөгчдийн мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, судалгаа, шинжилгээ хийх арга барилд сургах, бүтээлч сэтгэлгээ, аливаад дүрслэх, загварчлах, теник технологийн ур чадвартай байх зэрэг үндсэн үзүүлэлтүүдийг тусган боловсруулагдсанаараа онцлогтой байна.
- ҮТС-ийн хувьд Дизайны салбар нь 2 бакалаврын хөтөлбөрийг магадлан итгэмжлэл хийлгэсэн туршлагатай байна.

Анхаарах асуудал: /сул тал/

- 2014 оны шинэчлэлээр судалгаа хийлгүйгээр сургуулийн нэрнээс “Дизайн” гэсэн тодотголыг авснаар элсэлт, гадаад харилцаа бусад зүйл эрс суларсан байна. Одоо байгаа Үйлдвэрлэлийн Технологийн Сургууль гэсэн нэршлээс урлагийн сургууль гэсэн ойлголт харагдахгүй байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Оролцогч болон сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг хөтөлбөрийн агуулга, арга зүйн сайжруулалтад хэрхэн тусгаж буйг судалгааны тайлан болгон бэлтгэдэг байх.
- Хөтөлбөрийн хорооны гишүүдийн бүрэлдэхүүнд оролцогч, сонирхогч талуудын төлөөллийг оруулж, тэдний саналыг тусгадаг байх.

Шалгуур 1-ийн шинжээчийн багийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц гарган боловсруулсан.
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд хөтөлбөр сайжруулах дахин боловсруулах үйл ажиллагаанд ач холбогдолтой байна.
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээний харьцуулалт нь давуу сул талуудаа харж боловсруулах нээлттэй болгосон.
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ хийж дадлагын тайлан хамгаалуулж, үзэсгэлэн гаргаж, нийт оюутнуудад харилцан суралцах боломж олгож байна.
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа нь багш, оюутнуудын хөтөлбөрт суурилсан сургалтын боломжит нөхцөл хангаж байна.

Онцлог зүйл:

- График дизайн сургалтын төлөвлөгөөг нийгмийн хэрэгцээ шаардлагад уялдуулан боловсруулсан.
- Тус хөтөлбөрөөр суралцагч, төгсөгчийн сэтгэл ханамж өндөр байсан. (Суралцагч болон төгсөгчийн уулзалт, мөн ажил олгогчийн үнэлгээ)

Анхаарах асуудал:

- Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг эзэмшүүлэхэд чиглэсэн онол, практикийн зохистой харьцаатай байх, хичээл хоорондын агуулгын давхцал, уялдаа холбоог хэрхэн хангаж байгааг хэрхэн үнэлж, дүгнэдэг нь тодорхой бус байна.

Дүгнэлт:

- Мэдлэг бүтээх, багаар ажиллах, асуудал шийдвэрлэх, онол дадлагыг академик-практикийг хослуулах арга зүйг ашигласан.

- Үр дүнд суурилсан, Мэргэжлийн цогц чадамжид суурилсан, Судалгаанд суурилсан, Төсөлд суурилсан гэх мэт олон арга зүйг өргөн хэрэглэж, сургалтаа явуулдаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сургалтын агуулга нь хичээл хоорондын агуулгын давхцал байгаад үнэлгээ дүгнэлт өгдөг байх, мөн суралцагч сонгон судлах боломжийг нэмэгдүүлэх.
- Суралцагчийн практик ур чадвар олгоход чиглэсэн мэргэжлийн хичээлийн багц цагийг нэмэгдүүлэхэд анхаарах.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь суралцагч төвтэй, хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж гарын авлага гаргаж, оюутандаа хандсан хөтөлбөрийн нээлттэй хэлбэрийг гарган танилцуулсан байна.
- Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны баримт материалууд багшлах бүрэлдэхүүний нийтлэг боловсруулалт болж чадсан. Хөтөлбөрийг гол хэлбэрт оруулдаг зүйл бол арга зүйн залгамж холбоо гэж үзэж байна.

Онцлог зүйл:

- График дизайны хөтөлбөрийн мэргэжлийн онцлогоос хамааран асуудалд суурилсан сургалт, судалгаанд суурилсан сургалт, төсөлд суурилсан сургалтын аргуудыг хэрэглэдэг.
- Багш нарт сургалтын заах арга зүйн сургалтыг тогтмол явуулдаг.
- ШУТИС-ийн Захирлын 2016.02.05-ны тушаал “ШУТИС -ийн хөтөлбөрүүд CDIO загварыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” батлагдан мөрдөгдөж байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын агуулга, арга зүйг сайжруулах ажлын хүрээнд багш, суралцагчдад гарсан ахиц дэвшлийг үнэлдэг байх.

Дүгнэлт:

- Нийт багш нарын хичээлийн гол арга нь урлан гүйцэтгэх, сэтгэн бодуулах, орон зайн мэдрэмж, өнгө, хар зургийн ур хийцийн чадвар суулган бүх оюутнуудыг жигд хамруулан сургаж чадаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сургалтад нэвтрүүлж буй шинэлэг арга, аргачлал нь сургалтын хүрэх үр дүнд ямар үр нөлөөг өгсөнг хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлсэн баталгаажуулдаг байх

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа /Блум таксономи, Рубрик арга г.м/
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, амжилт, чанар г.м/

Онцлог зүйл:

- Сургалтын 1-16 долоо хоногийн хичээлийг Блүүмийн таксономи ашиглан дүгнэдэг нь оюутны хэт ачаалалд тэнцвэржүүлэлт хийж чадсан.
- 2011 оноос CDIO хэрэгжүүлсэн.
- Сургалтын мэдлэг чадвар хандлагыг бүрэн үнэлдэг.

Анхаарах асуудал:

- График дизайны хөтөлбөрийн хичээлүүдийн үнэлгээг Рубрикийн болон Блүүм таксономын аргыг ашиглан хичээл тус бүр дээр хэрхэн үнэлж, ямар үр дүн гарсаныг хөтөлбөрийн хүрээнд үнэлдэггүй.

Дүгнэлт:

- Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг.
- Багш нарын оюутныг мэргэжлийн ёс зүйн зөв хандлага, харилцаатай болгоход анхаарч, чиглүүлдэг байдал нь суралцагчийн сэтгэл ханамж, хийсэн бүтээлүүдээс нь харагдаж байлаа.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Үнэлгээний арга, аргачлалын давуу, сул талыг үнэлэн, хөтөлбөрт тохирсон шинэлэг үнэлгээний арга, аргачлалыг хэрхэн нэвтрүүлэх сургалтын бодлоготой байх.

Шалгуур 2-ын шинжээчийн багийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Тус сургуулийн сургалт, судалгаа явуулах зориулалт бүхий Урлан, лабораторийн 13 өрөө 662.54 м², лекц, семинарын анги танхим 5 өрөө 223м², багш нарын 5 өрөө-156 м² нийт 1041.54 м² талбай бүхий нийт 22 анги, танхим, урлан, лабораторитой. Хичээлийн нийт 4 (ШУТИС-ийн 1, 4, 8, Е-байр) байранд үйл ажиллагаа явуулдаг.

- Их сургуулийн хэмжээнд явагдаж байгаа оюутанд чиглэсэн нийтлэг үйлчилгээ болох оюутны байр, эрүүл мэндийн төв, оюуны хөгжлийн төвүүдээр суралцагч үйлчилгээ авах боломжтой. (Оюутны байранд 25 өрөө бүхий 300 оюутан хүлээн авах хүчин чадалтай 1 байр мөн эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ, оношилгоо хийх боломжтой эрүүл мэндийн 1 төвтэй)
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лабораторийг тохижуулах зорилгоор 2016 оноос хойш 321,938 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.
- Суралцагчийн бие даан болон багаар ажиллах анги танхим бий болгож, оюутны мэргэжлийн чиглэлийн “WHIZZ” клуб хичээллүүлж байна.
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа

Онцлог зүйл:

- ШУТИС-ийн харьяа “Горхи-тэрэлж”-д өөрийн гэсэн сургалт, судалгааны баазтай. Тус полигон дээр оюутнууд “Хэлбэр судлалын мэргэжлийн хичээл”-ээр 10 хоногийн хээрийн дадлага хийдэг.
- Одоо байгаа барилгыг цаашид шинэчлэх орчин үеийн сургалтын байгууллагын стандартыг хангасан шинэ барилга барих байшингийн зураг, тооцоо судалгааг 300 сая төгрөгийн зардлаар хийж, холбогдох дээд газруудад санал хүсэлтээ илгээсэн, шийдвэрлүүлэхээр ажиллаж байгаа. (Зураг төслөөр 9 давхар барилга)

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн эрэлт хэрэгцээ их, хөтөлбөрт суралцагчдын тоо сүүлийн хоёр жилд 2 дахин өссөн, цаашид суралцагч оюутны тоо нэмэгдэх хандлагатай байгаатай холбогдуулан мэргэжлийн сургалт явуулах анги, танхим, лабораторийн өрөө, техник тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамжийг эрэлттэй уялдуулан байнга нэмэгдүүлэхэд анхаарах.
- Сургалтын үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник технологийн шинэчлэлийг цаг алдалгүй нэвтрүүлэхэд анхаарах

Дүгнэлт:

- Тус хөтөлбөрөөр сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, студи, хээрийн дадлагын бааз, техник тоног төхөөрөмжтэй байна. ШУТИС-ийн хэмжээнд багш, оюутан нийтлэг үйлчилгээг авах боломж бүрдүүлж, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагыг хангаж байгаа тул тус дэд шалгуурыг бүрэн хангасан гэж үзэх үндэслэлтэй байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Цаашид сургуулийн удирдлага хичээлийн шинэ байр бариулах ажлыг эрчимжүүлэн, профессор багш, оюутны ажиллаж суралцах орчин нөхцөлийг сайжруулан, анги, танхим, урлан, студи, лабораторийн тоо, хүчин чадлыг нэмэгдүүлэх,
- Сургалтын техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үе шаттай тасралтгүй хэрэгжүүлэх.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн онцлогоос хамаарч хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангах зорилгоор нэг оюутанд дунджаар 5000-9000 төгрөгийг төсөвлөж, улирал бүр хичээл практикийн зардлаас олгодог.
- Тус хөтөлбөрийн 9 хичээлд албан ёсны лицензтэй 2 багц программ хангамжийг ашигладаг.
- Оюутны гарын авлагыг жил бүр цахим хэлбэрээр оюутны веб дээр байршуулж, заавар, удирдамж, зөвлөмжийг хүргэж хэвшсэн.
- Хамтын ажиллагааны гэрээтэй 20 гаруй байгууллага, компанитай хамтран ажиллаж, жил бүр 1-3 оюутныг дадлагад хамруулдаг.
- Дадлагын гэрээ, дадлагын удирдамж холбогдох материал, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа.

Онцлог зүйл:

- Сургалтын үйл ажиллагаанд удирдлага, мэдээллийн UNIMIS системийг ашиглаж багш, оюутан, сургалтын алба зэрэг бүх түвшинд хэрэглэж хэвшсэн.
- Цахим сургалтын UNILMS системд хөтөлбөрийн бүх хичээл байршуулж, MS office 360 программын тусламжтайгаар сургалтын бүх хичээлийг холимог хэлбэрээр зохион байгуулах боломж бүрдсэн.

Анхаарах асуудал:

- Сургалтын үйл ажиллагаанд ашиглах лицензтэй программ хангамжийг нэмэгдүүлэхэд анхаарах

Дүгнэлт:

- Сургуулийн зүгээс хичээлийн онцлогоос хамааран оюутнуудыг шаардлагатай хичээлийн хэрэглэл, материаллаг нөөцөөр хангахад зориулж улирал бүр тогтмол тодорхой зардлыг төсөвлөж, зарцуулдаг. Удирдлага мэдээллийн “UNIMIS” системийг сургалтын үйл ажиллагааг удирдах, цахим сургалтын “UNILMS” систем, MS office 360 программын тусламжтайгаар сургалтын бүх хичээлийг холимог хэлбэрээр зохион байгуулж байна. Сургалтад үнэгүй болон үнэтэй лицензтэй программуудыг ашиглаж байна. Оюутнуудыг дадлага хийх нөхцөл боломжоор хангаж, хамтын ажиллагааны гэрээтэй мэргэжлийн байгууллагад дадлага хийлгэж байна. Иймд тус дэд шалгуурыг бүрэн хангасан гэж үзэх үндэслэлтэй байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сургалтад хэрэглээний болон мэргэжлийн сургалтад чиглэсэн лицензтэй программуудыг ашиглахад анхаарч, сургуулийн жил бүрийн төсөвт санхүүжилтийг суулгаж ажиллах

3.3. Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Тус сургуулийн номын сан нь Төв номын сан болон тухайн сургууль дээр гэсэн 2 байршилд үйл ажиллагааг явуулдаг бөгөөд олон улсын номын сангийн түвшинд хүрэх зорилгоор нээлттэй-чөлөөт сонголтын үйлчилгээг номын сангийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна. Сургалтын агуулга, арга зүйд нийцсэн нийт 317 нэр төрлийн 647 ширхэг номтой. Үүнээс тус хөтөлбөрт шууд хэрэглэгддэг нийт 318 (ерөнхий суурь хичээлийн 88, мэргэжлийн суурь хичээлийн 110, мэргэжлийн хичээлийн 120) мэргэжлийн ном, сурах бичиг байна. Багш нарын гаргасан 9 мэргэжлийн ном сурах, бичиг гарын авлагыг pdf хэлбэрт шилжүүлж, оюутнуудад цахимаар ашиглах боломжийг бүрдүүлсэн.
- Номын сангийн фондын баяжилтыг ШУТИС-ийн ректорын 2008 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 16 тоот тушаалаар батлагдсан “Номын сангийн фонд бүрдүүлэлтийн журам”-ын дагуу хийдэг байна.
- Цахим мэдээллийн <http://must-libirary.edu.mn> хайлтын систем болон олон улсын мэдээллийн сан (EBSCO, OARE, Springer Nature зэрэг 10 гаруй сан)-г ашигладаг. Мөн хөтөлбөрийн багш, оюутнууд сургалтын үйл ажиллагаа, мэргэжлийн хичээлийн хүрээнд онлайн сургалтын платформ (Coursera, Skillshare, Udemy)-ыг ашигладаг.
- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, Сэтгэл ханамжийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа

Онцлог зүйл:

- Сургалтын үйл ажиллагаанд олон улсын 10 гаруй цахим мэдээллийн санг ашиглах боломж бүрдсэн.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн хичээлд шаардлагатай ном, сурах бичиг, гарын авлага, мэргэжлийн сэтгүүлийн хангамжийг нэмэгдүүлэх, цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулахад анхаарах.

Дүгнэлт:

- Тус сургуулийн номын сан нь “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага”-ыг хангаж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цахим үйлчилгээнүүдийг нэвтрүүлэн ажиллаж байна. Холбогдох дүрэм, журамд нийцүүлэн номын фондын баяжилтыг хэрэгцээт ном сурах бичиг, гарын авлагаар тогтмол хийж хэвшсэн. Номын сангийн үйл ажиллагаанд олон улсын мэдээллийн сан, цахим сургалтын платформ ашиглаж эхэлснээр багш, оюутнууд орон зай, цаг хугацааны хамааралгүйгээр цахим санг ашиглах боломжоор хангагдсан байна. Иймд тус дэд шалгуурыг бүрэн хангасан гэж үзэх үндэслэлтэй байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сургуулийн захиргаанаас төсөл хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлагыг нэмэгдүүлэхэд анхаарч, багш нараар захиалгаар ном, сурах бичиг, гарын авлага бичүүлж хэвлүүлэх ажлыг зохион байгуулж, санхүүжилтэд дэмжлэг үзүүлэх.

Шалгуур 3-ын шинжээчийн багийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС -ийн захирлын 2022.04.05 А/106 тоот тушаал “Өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх” тухай журам батлагдсан.
- ШУТИС -ийн захирлын 2017.10.09 А/182 тоот тушаал “ШУТИС-ийн Хөтөлбөрийн хорооны журам” баталсан.
- ШУТИС-ийн захирлын 2022.05.24 А/173 тоот тушаалын хавсралтад “Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах журам” батлагдсан.
- ҮТС-ийн Хөтөлбөрийн дэд хорооны 2021-2022 оны хичээлийн жилд хийх ажлын төлөвлөгөөг ҮТС-ийн Захирлын 2021 оны 09 сарын 30 өдрөөр баталсан. Мөн өнгөрсөн 3 хичээлийн жилийн хөтөлбөрийн дэд хорооны хурлын протоколууд.
- ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөг 2019 онд Ерөнхий захирлын тушаалаар баталсан.
- ҮТС-ийн дунд хугацааны 2022-2026 оны стратеги төлөвлөгөөг 2022.04.01 өдрийн Захирлын тушаалаар баталсан.
- ШУТИС-ийн захирлын 2019 оны 05 дугаар сарын 31 өдрийн А/129 тоот тушаалаар ШУТИС-ийн баримт бичгийн боловсруулалт, бүртгэл, хяналтын журам тус тус батлагдсан байна.

Онцлог зүйл:

- Өргөдөл, санал, гомдлыг хүлээн авч, хэрхэн шийдвэрлэсэн талаар 2020-2022 оны хичээлийн жилд нэгтгэн үнэлж, тайланг бэлтгэн гаргажээ.
- Холбогдох үйл ажиллагааны дүрэм журмууд төв ШУТИС-ийн захирлын тушаалаар боловсруулагдан гарч, бүрэлдэхүүн сургуулиудад мөрдөгдөж байна.
- Хөтөлбөрийн ерөнхий болон дэд хорооны үйл ажиллагаа тогтворжсон, тэр дундаа хөтөлбөрийн дэд хорооны хурлыг тогтмол хийж, хөтөлбөрийн өөрчлөлт шинэчлэлтийг хийдэг жишиг тогтсон.
- ШУТИС 2030 стратеги төлөвлөгөө хэрэгжиж эхэлсэн. Улмаар хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн дунд хугацааны 2022-2026 стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж байна.

Анхаарах асуудал:

- ШУТИС 2030 стратеги төлөвлөгөөний дагуу холбогдох салбарын ажлын төлөвлөгөөг уялдуулах, жил бүрийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хийдэг байх.
- ҮТС-ийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний дагуу холбогдох хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн үзүүлэлтийг уялдуулан сургууль, нэгжийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгч, ахиц дэвшлээ гарган тайлагнадаг байх.

- Оролцогч талуудаас авсан судалгааны үр дүн, жилийн болон улирлын тайланд дүн шинжилгээ хийж, ахиц дэвшлийг тухай бүрд дүгнэдэггүй болох нь ажиглагдсан.

Дүгнэлт:

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэгдсэн, хууль эрх зүйн баримт бичгийн боловсруулалт бүрэн хангагдсан тул шалгуурыг бүрэн хангасан гэж үзэх үндэслэлтэй байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- ШУТИС 2030 стратеги төлөвлөгөөний дагуу холбогдох салбарын ажлын төлөвлөгөөг уялдуулах, жил бүрийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хийдэг байх.
- ҮТС-ийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний дагуу холбогдох хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн үзүүлэлтийг уялдуулан сургууль, нэгжийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгч, ахиц дэвшлээ гарган тайлагнадаг байх.
- ҮТС, хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн хувьд богино, дунд, урт хугацааны төлөвлөгөөний дагуу ямар үр дүнд хүрсэн, улмаар өмнөх үзүүлэлтээс хэрхэн ахиц дэвшил гарснаа бодитоор үнэлдэг байх.
- Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, боловсруулахад нийгмийн болон бусад оролцогч, сонирхогч талуудын оролцоог нэмэгдүүлэх.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож ажилладаг нь дараах зүйлсээс харагдаж байна. Үүнд:
 - Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгүүд
 - Хамтарсан бүтээлүүд
 - Оюутан дадлагажуулах гэрээнүүд
- ҮТС-ийн үйлдвэрлэлийн мэргэшүүлэх дадлага хийлгэх тухай бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар батлагдсан хамтын ажиллагааны гэрээтэй 4 аж ахуй нэгж, дадлага хийлгэх 3 аж ахуй нэгж дээр оюутнуудыг дадлагад гаргасан байна.
- Багш солилцооны богино хугацааны хөтөлбөр хэрэгжсэн.

Онцлог зүйл:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь хамтын ажиллагааны хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулахад идэвхтэй оролцоотой байна. Тухайлбал,
 - 2023.01.16 өдөр ҮТС-ийн захирал болон Итагенси ХХК-тай хамтын ажиллагааны гэрээг байгуулж, улмаар уг гэрээний хүрээнд “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” цахим сургалтыг зохион байгуулж, сургалтын видео бичлэг, контентыг боловсруулан гаргасан байна.

- 2022.03.30 Долоон болдог ХХК -тай хамтран ажиллах гэрээг байгуулсан. Уг гэрээний гол зорилго “Үйлдвэрлэл- Сургалт- Эрдэм шинжилгээ”-ий хүрээнд хамтын ажиллагааг өрнүүлэх 5 жилийн хугацаатай 5 чиглэл дээр хамтран ажиллахад чиглэсэн байна.
- 2021.05.18 Kitchen all ХХК-тай хамтын ажиллагааны гэрээг байгуулж, цаашид үндсэн 5 чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Анхаарах асуудал:

- Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хийгдсэн ажлын тайлан, цаашид үйл ажиллагаандаа тусган сайжруулахад анхаарах ажлуудыг төлөвлөх.
- График дизайн хөтөлбөрийн төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг өргөжүүлэх. Улмаар төгсөгчдийн холбооны дүрэм, төгсөгчдийн холбооны хурлын тэмдэглэл, төгсөгчдийн холбооны гишүүдийн мэдээлэл, төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд зэрэг нь төгсөгчдийн холбоо төгсөгчдөд зориулж тодорхой арга хэмжээнүүд зохион байгуулж, эргэх холбоотой ажиллахад анхаарах.
- Суралцагч солилцооны хүрээнд хийгдэх үйл ажиллагааг өргөжүүлэх

Дүгнэлт:

- Дотоодын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож ажиллахад хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж анхааран ажилладаг, мэргэжлийн чиглэлийн байгууллагуудын захиалгат төсөл, хөтөлбөрийг хамтын ажиллагааны гэрээний хүрээнд багш, суралцагчдын хүрээнд хамтран хэрэгжүүлдэг туршлагатай, улмаар сургалт, судалгаа, семинар зэрэг олон талт хэлбэрээр хамтын ажиллагааг өргөжүүлж ажилладаг байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- График дизайн хөтөлбөрийн төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг өргөжүүлэх, эргэх холбоотой ажиллахад анхаарах.
- Эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр дотоодын болон гадны улс орнуудын сургалтын болон судалгааны байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн захирлын 2018.12.18 А/248 тоот тушаалаар “Санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах журам батлах тухай” батлагдсаны дагуу бүрэлдэхүүн сургуулиудад хуваарилалт хийгддэг.
- ШУТИС-ийн захирлын 2022.04.29 А/145 тоот тушаалаар “ШУТИС -д төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэх журам” батлагдсан. Энэ журмын дагуу ҮТС-ийн Дизайны салбарын хувьд санхүүжилт оруулсан туршлагауд байна.

- “Алтан хулгана” наадмын 2018, 2019 онуудын орлого, зарлагын нэгдсэн тайлан мэдээлэл
- ШУТИС-ийн 2021-2022 оны хичээлийн жилийн хүрээнд хийсэн ажлын тайланг сургуулийн хэмжээнд нэгтгэн ном жил бүр гаргадаг. Уг тайланд ҮТС-ийн Дизайны салбарт 60 сая төгрөгийг төсөвлөж, 57 сая гаруй төгрөгийн гүйцэтгэл гарсан нь төсөвлөгдсөн хөрөнгө 96 хувьтай зарцуулагджээ.
- ШУТИС-ийн захирлын 2021 оны 01 сарын 29 өдрийн А/16, 06-р сарын 18 өдрийн А/108, 12 сарын 24 өдрийн А/245 тоот тушаалаар бүрэлдэхүүн сургууль, нэгж хоорондын орлогын төсөв, гүйцэтгэлийг баталсан байна. Үүний дагуу ҮТС-ийн хүрээнд нийт төсөвлөсөн орлогын 94.35%-ийг биелүүлсэн байна. Мөн зарлагын төсөв, гүйцэтгэлийн хувьд 2021 оны 03 сарын 03 өдрийн ШУТИС-ийн санхүү эрхэлсэн дэд захирлын 5/100 тоот албан бичгийн хүрээнд зардлын хэмнэлт хийх ажлын хүрээнд ҮТС-ийн хувьд 68.65% гүйцэтгэлтэй байна.

Онцлог зүйл:

- “Алтан хулгана” наадмын үйл ажиллагаатай холбоотой санхүүжилт болон хөрөнгө оруулалтыг сургуулийн нэгдсэн дансаар авч, олсон орлогын 10 хувийг сургуулийн төсөвт төвлөрүүлдэг. Уг наадам нь улсын хэмжээнд зохион байгуулагддаг онцлогтой төдийгүй санхүүжилтийн асуудлыг бие даан шийдвэрлэх, хөрөнгө оруулагч, хандивлагчаа хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн удирдлага, багийн гишүүд өөрсдөө олдог нь давуу тал байна.
- Мянганы сорилын сангийн “Мэргэжлийн боловсрол сургалтын төслийн хүрээнд “Мультимедиа сургагч багш” бэлтгэх сургалтад 67 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг сургуулийн санхүүд хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн “График дизайн” хөтөлбөрийн багш нарын баг оруулсан. Уг орлогын 10 хувийг мөн сургуулийн нэгдсэн дансанд хөрөнгө оруулсан байна. Үр дүнд нь 5 багшийн докторантурын сургалтын төлбөрийг төлсөн, мөн лабораториудыг тохижуулалтад зарцуулагдсан байна.
- Дизайны салбар сургуульд 2022 онд 8.7 саяын ухаалаг самбар иж бүрдэл, 2.6 саяын проектор, аппарат, 1.8 саяын төгрөгийн шилэн самбар. Мөн анги, лабораториудад 8.7 саяын ухаалаг самбар их бүрдэл зэргийг шинэчлэн нэмж авсан байна.
- Санхүүгийн тайланд дотоод аудит болон хөндлөнгийн аудит хийлгэдэг туршлагатай.

Анхаарах асуудал:

- Сургуулийн санхүүгийн нэгдсэн тайлан нь төв сургуулийн санхүүгийн нэгдсэн тайлан тооцоогоор гарсан нь хөтөлбөр хэрэгжүүлэгч салбарын санхүүгийн хувьд биеэ даасан байдал харагдахгүй байна.
- Одоогоор График дизайны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа багшийн хөгжилд, оюутны эрдэм шинжилгээний ажилд зориулан гаргах мөнгөн хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэл харагдахгүй байна.
- Нэг оюутанд ногдох өртөг зардлын тооцоог сургуулийн нэгдсэн тооцоогоор гаргасан нь “График дизайн” хөтөлбөрийн хувьд хүрэх үр дүнд чиглэсэн төсөв, зарцуулалт бодитой тодорхой бус байна.
- Нэг оюутанд ногдох зардлаа хичээл бүрээр тооцож, нийт тус хичээлийг судлах оюутны тоонд хуваан нэг оюутанд ногдох зардлыг гаргасан байгаа нь бүрэн тооцоологдоогүй байна. Тухайлбал, сургалтаас гадна судалгаа, эрдэм

шинжилгээ, нийгмийн үйл ажиллагааны хүрээнд шингэх зардлуудын талаарх мэдээлэл нарийвчилсан зүйл харагдсангүй. Нэг оюутанд дунджаар 9000 төгрөг нэг хичээл дээр төсөвлөгдсөн байна.

Дүгнэлт:

- Хөтөлбөрийн санхүүжилтийн гол эх үүсвэр нь төв сургуулийн нэгдсэн төсвөөс хуваарилагддаг, хөтөлбөр хэрэгжүүлэгч салбарт нийт төсвийн 39 хувийг зарцуулдаг. График дизайн хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь санхүүгийн эх үүсвэрийг мэргэжлийн тодорхой үйл ажиллагаануудын хүрээнд бие даан бүрдүүлдэг зэрэг нь онцлог байв.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Нэг оюутанд ногдох өртөг зардлыг График дизайны мэргэжлийн хөтөлбөрийн хувьд тооцох. Улмаар хөтөлбөр сургуульд эдийн засгийн хувьд ямар үр ашигтай эсэх, өртөг зардлын тооцооллыг хийж үнэлэн дүгнэж байх.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн багшийн хөгжилд, оюутны эрдэм шинжилгээ судалгааны ажилд зориулсан төсвийг жил бүр батлан өгч гүйцэтгэлийг хангаж ажиллах.
- Төсөл, хөтөлбөр, сургалт, судалгааны ажил зэрэг олон эх үүсвэрээс санхүүжих боломжийг жил жилээр тодорхойлон төлөвлөж, хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн оролцоог хангаж ажиллах.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- “Алтан хулгана” наадмын мэдээлэл, сурталчилгааны ажлын төлөвлөгөө, хэрэгжилт
- Мэргэжил сурталчлах өдөрлөгийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний ажлын төлөвлөгөө, тайлангууд
- Элсэгч, төгсөгчдөд зориулсан “ШУТИС бидний бахархал” өдөрлөг сургалт, ЭШХ, багш оюутны бүтээлийн үзэсгэлэн, ЕБС сурагчдад зориулсан 1 өдрийн сургалтын төлөвлөгөө, тайлан
- 2018 онд зохион байгуулсан “TYPOMANIA” багш, суралцагчдын бүтээлийн үзэсгэлэнгийн тайлан.
- “ART+ Design+ARCH ADA” үйл ажиллагааг багш, оюутны хүрээнд зохион байгуулдаг.
- Сургуулийн вэб сайтад бүрэлдэхүүн сургуулийн цэсэнд мэргэжлийн хөтөлбөр, сурталчлан таниулах мэдээллүүдийг тусгасан байна.

Онцлог зүйл:

- “Алтан хулгана” наадам нь улсын хэмжээнд зохион байгуулагддаг онцлогтой, Тус наадмын цахим сурталчилгааны ажил эрчимтэй явагдаж байв.
- “DESIGN VITALITY FESTIVAL” наадмыг жил бүр зохион байгуулдаг уламжлалтай.

- Элсэгч, төгсөгчдөд зориулсан ШУТИС бидний бахархал өдөрлөг сургалт, ЭШХ, багш оюутны бүтээлийн үзэсгэлэн, ЕБС сурагчдад зориулсан 1 өдрийн сургалт зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Элсэгчдийн тоо сүүлийн 2 жилд өссөн харагдаж байна. Цаашид элсэгчийн тоог нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийн төлөвлөгөөг гаргадаг байх.
- Сургуулийн веб сайтад бүрэлдэхүүн сургуулийн цэсэд мэргэжлийн хөтөлбөр, түүний онцлог давуу талыг сурталчлан таниулах мэдээллүүдийг тусгах, шинэчлэх.

Дүгнэлт:

- Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн бодлоготой байгаа нь улсын болон мэргэжлийн хэмжээнд зохион байгуулагддаг тогтмолжсон арга хэмжээнүүдээс харагдаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Маркетинг идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг сайжруулах, хөтөлбөрийг онцлог, давуу талаа сурталчлан таниулах арга хэмжээнүүдийг төлөвлөн ажиллах. Улмаар элсэлтийн маркетингийн төлөвлөгөөтэй байхад анхаарах.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд “Тэрбум мод тарих” аян өрнүүлж, мод тарих, үржүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан тайлан. 2022.06.03-04 өдрүүдэд.
- [ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ \(sitech.edu.mn\)](http://sitech.edu.mn) сургуулийн вэб сайтад тухайн бүрэлдэхүүн сургууль, хөтөлбөр, дүрэм журам, онцлог арга хэмжээ, үйл явцын мэдээллүүдийг тусгасан байна. Элсэлт цэс дотор хөтөлбөрийн танилцуулга мэдээлэл орсон байна.
- Сургалтын процесс багш, оюутан, сургалтын бүхий л үйл ажиллагааг UNIMUS system ашигладаг.
- Сакура Science хөтөлбөрийн хүрээнд ахисан түвшинд График дизайны хөтөлбөрөөс 2 хүн хамрагдсан байна. Бакалаврын түвшинд 4 оюутан тэтгэлэг авч суралцсан.

Онцлог зүйл:

- 2014 оноос Cloud university системд шилжсэн
- Мэргэжлийн чиглэлээр зохион байгуулагддаг улсын чанартай тэмцээн, уралдаан, наадам нь хөтөлбөрийг сурталчлан таниулах, нээлттэй харуулах гол идэвхжүүлэлт болдог.
- Сүүлийн 2 хичээлийн жилд элсэгчдийн тоо өссөн.

Анхаарах асуудал:

- Вэб сайтын мэдээлэл шинэчлэгдсэн ч бүрэлдэхүүн сургууль График дизайн хөтөлбөрийн мэдээлэл дутмаг байна. Тухайлбал, хөтөлбөрийг сурталчлан таниулах ажлууд хязгаарлагдмал харагдаж байна.

Дүгнэлт:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг сургуулийн вэб сайт болон цахим сүлжээгээр түгээдэг байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн цахим хуудас ашиглах, вебсайтын мэдээллийн иж бүрэн байдалд анхаарах.

Шалгуур 4-ийн шинжээчийн багийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйлчилгээ

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- “ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрийн элсэлтийн журам”-ын 6 дугаар бүлэгт ур чадварын шалгалтын шаардлага, үнэлгээний аргачлалыг тусгасан бөгөөд тус хөтөлбөрт элсэхийг хүсэгчдээс мэргэжлийн авьяас, ур чадварын шалгалт авах аргыг боловсруулсан байна. Үүнд: Тестийн гүйцэтгэл -300, Зохиомж, байгуулалт, хэлбэр харьцаа -250 оноо, Материаллаг шинж чанар, эзлэхүүн, зураглал, алслалт, гүйцэтгэл-250, нийт 800 оноогоор дүгнэдэг. Мөн хийсэн уран бүтээл, эсээ бичлэгээр хүсэл тэмүүллийг нэмэлт оноогоор дүгнэдэг байна.
- “ШУТИС-2030” хөгжлийн бодлого (ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн №01 тогтоол)
- БШУЯ, ШУТИС-ийн Оюутан элсүүлэх журам (тайлант хугацаагаар)
https://www.must.edu.mn/mn/elseltiin_juram_2020/
- Элсэлтийн цахим бүртгэлийн систем <https://elselt.edu.mn/>
- ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн элсэлтийн мэдээлэл хүргэх гар утасны аппликейшн
https://play.google.com/store/apps/details?id=com.mustuts.must_elselt&hl=mn&gl=US
- Элсэлтэд зориулсан төсвийн зарцуулалт (тайлант хугацаагаар)

Онцлог зүйл:

- Багш нарын төлөөллийг хөдөө, орон нутагт томилолтоор явуулж мэргэжлээ сурталчлан, элсэлт зохион байгуулдаг.
- Үндэсний хэмжээнд зохион байгуулсан уралдаан тэмцээнд шагналт байр эзэлсэн элсэгчдэд “Урилга” өгч, ур чадварын шалгалтгүйгээр элсүүлдэг.

Анхаарах асуудал:

- Гадаад оюутны элсэлтийн тоо хангалтгүй.

Дүгнэлт:

- Тус хөтөлбөрт элсэгчдийг БШУЯ, ШУТИС-иас баталсан журамд нийцүүлэн хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуур (авьяас, ур чадварт суурилсан)-аар уралдаант шалгалт зохион байгуулж, суралцах хүсэл тэмүүлэл, сонирхлыг харгалзан үзэж элсүүлдэг тул тус дэд шалгуурыг бүрэн хангасан гэж үзэх үндэслэлтэй байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Гадаад элсэлт зохион байгуулах үе шаттай, цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэн, гадаад оюутны элсэлтийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Зөвлөх багш томилсон тушаал (Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн захирлын 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн №А/64 тоот, 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн №А/56 тоот, 2022 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн №А/47 тоот тушаал)
- “Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцох журам”-ын Сургууль олон нийтийн үйлчилгээ “В” цаг 11-р бүлэг (ШУТИС-ийн ректорын захирлын 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А265 тоот тушаал). https://www.must.edu.mn/media/uploads/2022/10/03/8must_.pdf
- Үйлдэрлэлийн технологийн сургуулийн Оюутны гарын авлага <https://www.must.edu.mn/media/uploads/2023/01/19/garin-awlaga-2022-5.pdf>
- Оюутны үйлчилгээ, хөгжлийн хүрээнд хийх ажлын хичээлийн жилийн график төлөвлөгөө, тайлан (тайлант хугацаагаар)
- Оюутны сэтгэл ханамжийн судалгааны дүн (тайлант хугацаагаар)

Онцлог зүйл:

- Сургуулийн зүгээс шинээр элсэгч оюутнуудын дунд дасан зохицох, сургуулийн дүрэм журам, оюутны эрх, үүрэг, ирээдүйн ажил мэргэжлийн талаар ойлголт өгөх, зөвлөгөө мэдээлэл хүргэх, цагийн ажилд зуучлах, цалинтай дадлага хийлгэх зэрэг ажлыг тогтмол зохион байгуулж, хэвшсэн.

Дүгнэлт:

- ШУТИС-ийн хэмжээнд суралцагчид суралцах, судлах арга зүй, хууль эрх зүйн мэдлэг олгох, сургуулийн орчинд дасан зохицох чиглэлээр мэдээлэл хүргэх, зөвлөх үйлчилгээг жил бүр график төлөвлөгөөнд тусгаж, нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулж, хэвшсэн. Мөн оюутнуудыг чиглүүлэх зорилготой оюутны зөвлөх багш нарыг томилж ажиллуулдаг. Иймд тус дэд шалгуурыг бүрэн хангасан гэж үзэх үндэслэлтэй байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутанд зориулсан мэргэжлийн уралдаан тэмцээний удирдамж, төсвийн зарцуулалт, гэрэл зураг, нийтэд мэдээлсэн мэдээ мэдээллүүд, постер, хэвлэлүүд.
- Тус хөтөлбөрөөр суралцагч оюутнуудын дунд Монгол Улсаас “Алтан хулгана” олон улсын наадмыг зохион байгуулж, оролцохын зэрэгцээ БНХАУ-ын ӨМӨЗО-ны Үйлс бүтээлийн дээд сургуулийн “Дизайны олон улсын наадам”, ОХУ-ын “Оросын дизайнеруудын холбоо” “Москвлагийн музей”-гээс зохион байгуулдаг “Орчин үеийн дизайн дахь соёлын өв” олон улсын графикайн тэмцээн, Япон улсын “Ивате” их сургуулиас зохион байгуулдаг “Art and Thoku” олон улсын наадамд оюутнуудыг амжилттай оролцуулдаг байна. Тухайлбал, “Art and Thoku” олон улсын наадамд 5 жилийн хугацаанд нийтээр 35 бүтээл, “Орчин үеийн дизайн дахь соёлын өв” олон улсын графикайн тэмцээнээс 5 бүтээл, “Дизайны олон улсын наадам”-аас 7 бүтээл тус тус шалгарсан байна.
- Гаднын байгууллагын урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд-7, Захирлын нэрэмжит тэтгэлэгт-1 (30 кр цаг) сурлагын голч дүнгээр урамшуулалт тэтгэлэгт-46 оюутан (46 кр цаг) тус тус хамрагджээ.
- Холбогдох журам, тайлан мэдээ

Онцлог зүйл:

- Оюутны бүтээлч сэтгэлгээ, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр “Алтан хулгана” олон улсын наадмыг тогтмол зохион байгуулж, оролцож хэвшсэн.

Анхаарах асуудал:

- Оюутны сайн дурын клуб, уралдаан тэмцээн, оюутны хөгжилд чиглэсэн үйл ажиллагааны зардлыг бууруулахгүй тогтвортой байлгахад анхаарах.
- Оюутны сайн дурын ажил, үнэлгээ, урамшууллыг тооцох асуудалд анхаарах

Дүгнэлт:

- Сургуулийн зүгээс суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажиллах зорилгоор оюутны бүтээлч сэтгэлгээ, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх “Алтан хулгана” олон улсын наадмыг зохион байгуулдаг. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд оюутны бүтээлийг олон улсын уралдаан, наадам, тэмцээнд оролцуулах, гаднын болон сургуулийн нэрэмжит тэтгэлэгт хамруулах ажлыг зохион байгуулж, хэвшсэн тул тус дэд шалгуурыг бүрэн хангасан гэж үзэх үндэслэлтэй байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Оюутны сайн дурын клуб, уралдаан тэмцээн, оюутны хөгжилд чиглэсэн үйл ажиллагааны зардал “Ковид-19” цар тахлын үед буурсан учир цаашид оюутны үйл ажиллагааг дэмжиж, хэмжээг нэмэгдүүлэх.
- Оюутны сайн дурын ажлыг үнэлэх, урамшуулах тогтолцоог бүрдүүлэн, төгсөгчдөд батламж, тодорхойлолт гаргадаг болох.

- “Ковид-19” цар тахлаас шалтгаалан тасалдсан оюутны хамтарсан гадаад дадлага, оюутан солилцоог сэргээх.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам (ШУТИС-ийн ректорын 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/134 тоот тушаал) <https://must.edu.mn/media/uploads/2022/12/07/3bakalavar-1.pdf>)
- Шилжилт хөдөлгөөний тайлан мэдээ (2018-2023)

Онцлог зүйл:

- Сүүлийн жилүүдэд хөтөлбөрийн нэр хүнд, эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор гаднаас шилжин суралцаж байгаа оюутны тоо нэмэгдэж, сургуулиас гарсан оюутны тоо буурсан байна.

Дүгнэлт:

- ШУТИС-ийн холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн шилжилт, хөдөлгөөний өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэхдээ сургуулиас гарах болон шилжин ирж байгаа шалтгааныг тухай бүр тодруулж ажилладаг байна. Иймд тус дэд шалгуурыг бүрэн хангасан гэж үзэх үндэслэлтэй байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Тайлант хугацаанд тус хөтөлбөрөөр нийт 109 оюутан төгссөн.
- Бакалаврын дипломын хуулбар, архивын нэгж (Тайлант хугацаанд)
- БСШУ-ны сайдын “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” тушаалыг үндэслэн ШУТИС-ийн ректорын тушаалаар голч дүн 2.0-оос багагүй дүнтэй төгсөгчдөд диплом, энгэрийн тэмдгийг олгодог. Голч дүн 3.6 ба түүнээс дээш дүнтэй төгсөгчдөд онцлох диплом олгодог.

Онцлог зүйл:

- “График дизайн” хөтөлбөрийн оюутнууд бие даасан төгсөлтийн ажил (уран бүтээл) гүйцэтгэж, үүнийг ШУТИС-ийн төгсөлтийн салбар комисс дүгнэдэг.
- Төгсөлтийн баримт бичигт дүн тулгалтыг 3 үе шаттай зохион байгуулж, хяналт хийдэг.

Дүгнэлт:

- БСШУ-ны сайдын 2006 оны 480 дугаар тушаалаар баталсан “Дээд боловсролын диплом олгох журам”, 2012 оны 1 дүгээр тушаалаар баталсан “Боловсролын

баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” дүрэм, журмыг мөрдлөг болгон тус хөтөлбөрөөр төгсөгчдөд төгсөлтийн баримт бичгийг монгол, (кирилл, монгол бичгээр) англи хэлээр үнэт цаасан дээр хэвлэж, энгэрийн тэмдгийн хамт олгодог. Төгсөлтийн баримт бичигт суралцагчийн эзэмшсэн хөтөлбөр, мэргэшлийн мэдээлэл, суралцсан хугацааны дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан тул дэд шалгуурыг бүрэн хангасан гэж үзэх үндэслэлтэй байна.

Шалгуур 5-ын шинжээчийн багийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн чиглэсэн үйлчилгээ

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн захирал 2015 оны 02 сарын 05 ны өдрийн А,22 тоот шалгуур үзүүлэлтээр багш сонгон шалгаруулт хийдэг.
- Тухайн хөтөлбөрт шаардлага хангасан мэргэжлийн ур чадвар, харилцаа хандлага, багаар ажиллах чадварыг харгалзан тэнхимийн хамт олноор хэлэлцэн ярилцаад сонгон шалгаруулалтыг явуулдаг байна.
- Шалгаруулалтад тэнцээд орж ирсэн багш, дадлагажигч багшаар 1-2 жил ажилдаг.
- Дадлагажигч багшийг зөвлөн туслах нэг профессор багш ажиллана.
- Шалгуур үзүүлэлтүүдээ гадаад хэлний шалгууртаа тухайн багш өөрийн мэддэг хэлээр шалгуулах боломжтой.
- Дагалдуулагч профессорын санал нь гол үзүүлэлт болдог.

Онцлог зүйл:

- Багш болох сонгон шалгаруулалтыг нээлттэй, тухайн тэнхимийн хамт олон гол үүргийг гүйцэтгэдэг давуу талтай байна.
- Шалгуулгуулагч багш өөрөө хэл сонгодог.
- Англи хэлний өндөр түвшин хангасан шалгуулагч нь шалгуулахгүй тооцдог.
- График дизайн хөтөлбөрийн хүрээнд хичээл ордог 5 доктор, профессор багш нар байна. Бусад багш нар докторантурт суралцаж байгаа, ахлах багш, магистр багш нар ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Ур чадвартай, мэргэжлийн багшийн нөөцөө тогтвортой байлгах бодлоготой байх, мөн хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс материаллаг орчны нөхцөл байдлыг сайжруулахад анхаарч өгөх

Дүгнэлт:

- График дизайн хичээлийн хөтөлбөрт багшлах боловсон хүчний профессор, дэд профессор, ахлах багш нар залуу багш нараа дагалдуулан сургах залгамж холбоогоо бэлтгэх бодлоготой байдаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Ур чадвартай, мэргэжлийн багшийн нөөцөө тогтвортой байлгах бодлоготой байх.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс материаллаг орчны нөхцөл байдлыг сайжруулахад анхаарах.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- А цаг нь сургалтын үйл ажиллагаанд хэрхэн хандаж байгааг оюутнуудын бүтээл, хичээл хоорондын уялдааг өнпөр хэмжээнд хангасан байна. Мэргэжилдээ хандах хандлага, түүнийгээ өөрийн болгох ур чадвар суулгах нь багш нарын хүч, хөдөлмөр гэж болно.
- Б цаг нь Эрдэм шинжилгээ иновацийн үйл ажиллагааг бүх сургууль даяараа багш нарыг оролцуулах, идэвхийг нэмэгдүүлэх, багшдаа эрдэмжих боломжуудыг гаргаж өгдөг давуу талууд байна.
- В цаг хамт олон, олон нийтийн үйл ажиллагааг хамт олон өөрсдийн боломж, нөөц, нэгнээ орлон гүйцэтгэх, хөрвөн ажиллах чадварууд өндөр байна. Баг хамт олны нэгдсэн уур амьсгал, тэдгээрийг удирдан сайжруулах нь удирдлагуудын ур, харилцаа хандлага харагдаж байлаа .

Онцлог зүйл:

- Багшийн хөгжлийн төвтэй, заах арга зүй, мэргэжлийн ур чадварт үнэлгээ өгдөг.
- Профессорын семинар, нээлттэй хичээлийг бүх багш нараар хамруулан оруулж хамтран хэлэлцдэг.
- 3 жилд нэг удаа аттестачлал хийгдэнэ.

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн үнэлгээ дутмаг.
- Багшийн суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааны үр дүнгээ үнэлэн, цаашид хэрхэн хэрэгжүүлэх арга замаа тодорхой болгох.

Дүгнэлт:

- Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийсэн ажлын баримтууд тодорхой хэмжээнд байна.
- Багшлах ур чадвар, суралцагчдын сэтгэл ханамж, сургуулийн зүгээс үзүүлэх дэмжсэн тодорхой ажлууд хийгдсэн.

Үнэлгээ: Бүрэн хангасан/**Зөвлөмж:**

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг үнэлсэн талаар тайланг бэлтгэдэг байх.
- Багш солилцооны хөтөлбөрийг эрчимжүүлэх, багшийн хөгжил, мэдлэг, ур чадварыг ахиулах туршлага солилцоо гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд анхаарах.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Олон улсын Герман, Итали, ОХУ, ӨМӨЗО зэрэг улсуудын сургалт, эрдэм шинжилгээ хамтын ажиллагааг өргөжүүлж байна. Эрдэм шинжилгээ судалгааны ажлын чанарыг сайжруулах, гэрээт ажлыг гүйцэтгэх, багш нар, магистрант, докторант нарын судалгааны ажлыг хэлэлцүүлж 14 хоног тутам хэлэлцүүлэг явуулдаг байна. Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентийн тоон судалгааны мэдээлэл
- Бодлогын баримт бичиг, дүрэм журам
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал
- Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо
- Зарцуулсан төсөв, тайлан

Онцлог зүйл:

- Европын холбооны ERASMUS төслөөр 12 багшийн бүрэлдэхүүнтэй баг амжилттай ажиллаж байгаа нь гадаад хамтын ажиллагаа, сургалтын үр дүнд эерэг хандлага, харилцан туршлага солилцох боломж хангаж байна.
- Багш нар мэргэжлийн гадны 6 төсөл, дотоодын 10 гаруй төсөл дээр ажиллаж байсан туршлагатай.

Анхаарах асуудал:

- Уран бүтээлч багш нарын уран бүтээл, мэргэжлийн уралдаан тэмцээний үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үнэлгээнд тусгах боломжийг судлах.
- Багш нарыг мэргэжлийн уралдаан тэмцээнд ороход нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

Дүгнэлт:

- ӨМИС-ийн Үйлс бүтээлийн сургуультай хувцасны судалгааны төсөлд хамтарч ажиллаж байгаа нь хөрш зэргэлдээ орнуудын техник, технологийн дэвшил, сургалтын арга зүй, хамтын ажиллагааг өргөжүүлж байгааг харуулж чадсан байна.
- Багш нарын зүгээс оюутны эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх, дагалдан сургах, удирдах ажил хангалттай сайн хийгдэж байна..

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Уран бүтээлч багш нарын уран бүтээл, мэргэжлийн уралдаан тэмцээний үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг мэргэжлийн онцлог, ур чадвар, бүтээлийн бодит байдалтай уялдуулан эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үнэлгээнд тусгах боломжийг судлах
- Багш нарыг мэргэжлийн уралдаан тэмцээнд ороход нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжийг бий болгох

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайланд 100 онооны 15 оноог удирдлага өгдөг.
- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Хөндлөнгийн үнэлгээний дүн
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайлан мэдээ
- Багшийн хавтас

Онцлог зүйл:

- Багшлах бүрэлдэхүүний 19.8 % цолтой.
- Багшлах бүрэлдэхүүний 80 % нь 6-аас дээш жил ажилласан.
- Мэргэжлийн уралдаан тэмцээнд уран бүтээлч багш нарыг дэмжин оролцуулдаг.

Анхаарах асуудал:

- Мэдлэг, ур чадвартай багшлах бүрэлдэхүүнийг дэмжин ажиллах, улмаар багшийн тогтвор суурьшилтай ажиллах хүний нөөцийн бодлоготой байх.
- Багш нарын заах арга зүйн чадамжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа, бодлогыг сургуулийн стратеги төлөвлөгөөнд тусгадаг байх.

Дүгнэлт:

- Оюутнуудаас багшлах үйл ажиллагаанд үнэлгээ өгдөг. Үнэлгээг салбарын эрхлэгч, сургалт эрхэлсэн дэд захирлуудын баг нэгтгэн дүгнэдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Багшлах бүрэлдэхүүнийг тогтвор суурьшилтай ажиллах хүний нөөцийн бодлоготой байх
- Багш нарын заах арга зүйн чадамжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа, бодлогыг сургуулийн стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхэд анхаарах

Шалгуур 6-ын шинжээчийн багийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн Захирлын 2019 оны 03 дугаар сарын 22 өдрийн А/70 тоот тушаалаар Чанарын бодлого, чанарын зорилтод хүрэх төлөвлөгөөг баталсан байна.
- ШУТИС-ийн Захирлын 2019 оны 05 дугаар сарын 31 өдрийн А/128 тоот тушаалаар ШУТИС-ийн үйл ажиллагаанд чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх журам батлагдсан.
- Чанарын менежментийн тогтолцоонд дотоод аудит хийх тухай ШУТИС-ийн захирлын 2021 оны 12 сарын 21 А/241 тушаалын баталсан байна. Уг тушаалын хэрэгжилт, үр дүнд ШУТИС-ийн чанарын менежментийн тогтолцооны дотоод аудитын тайланг бэлтгэн гаргасан байна. Улмаар цаашид залруулах арга

хэмжээг авах тушаал гарган хэрэгжүүлсэн нь үр дүнгээ үнэлж, цаашид хэрэгжүүлэх арга замаа тодорхойлсон давуу тал байна.

Онцлог зүйл:

- Сургуулийн хэмжээнд 1 чанарын менежертэй, чанарын менежерийн ажлын төлөвлөгөө, тайлантай танилцлаа. Төлөвлөгөөний хэрэгжилтэнд нэмж гарсан санал, анхаарах зүйлүүдийг 2021-2022 оны хичээлийн жилд тайланг бэлтгэн гаргасан байна.
- ҮТС-ийн захирлын тушаалаар 2021 оны 10 сарын 28 А/70 тоот тушаалаар Чанарын баг байгуулах тушаалыг гаргасан байна. Бүрэлдэхүүн сургуулийн чанарын баг болон чанарын менежерийн хувьд уг тушаал, дүрэм журмын хүрээнд ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл тайлан, залруулах арга хэмжээг авч үйл ажиллагаага үнэлжээ.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхэд хөтөлбөрийг сайжруулахад системтэй ашигласан талаарх мэдээлэл баримт дутмаг байна.

Дүгнэлт:

- Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизм тогтворжсон байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Бүрэлдэхүүн сургуулийн чанарын менежерийн ажлын төлөвлөгөөг сургуулийн дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөө, чанарын нэгдсэн баталгаажуулалтын журамд уялдуулан гаргах.
- Хөтөлбөрийн оролцогч, сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, санал хүсэлтийг авч цаашид хэрхэн сайжруулах талаар тусгах.
- Хөтөлбөр сайжруулалтад хөндлөнгийн үнэлгээг хийх аргачлалыг бий болгох

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Оролцогч, сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, тайлан
- Төгсөгчийн сэтгэл ханамжийн судалгааг сүүлийн 3 жилд цаасан хэлбэрээр авсан.
- Ажил олгогчоос хөтөлбөрийн сайжруулалттай холбоотой санал хүсэлтийг авдаг.
- Ажил олгогч талуудтай хийсэн хамтын ажиллагааны гэрээнүүд
- Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, мэдээлэл

Онцлог зүйл:

- Сургалтын албанаас хичээлийн жилд 2 удаа суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааг авч, үнэлэлт, дүгнэлт өгөх байдлаар сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт хяналт тавьдаг.

- Ажил олгогчийн зүгээс тус хөтөлбөрөөр төгсөгчдийн мэргэжлийн ур чадвар, харилцаа, хандлага сайтай гэж цахим уулзалтаар санал хэлсэн .
- Төгсөгчид суралцаж байх хугацаандаа мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцож мэдлэг чадвар сайн эзэмшдэг, төгсөгчдийн чанар сайн байгааг онцолсон.

Анхаарах асуудал:

- Оролцогч, сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны тайлангууд бүрэн бичигдээгүй, судалгааны үр дүнгийн дагуу авсан арга хэмжээ тодорхой бус байна.
- Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, түүний дагуу авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа дутмаг байлаа.

Дүгнэлт:

- Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах мэдлэг, ур чадвартай байгааг ажил олгогч талын уулзалт ярилцлага, сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Оролцогч, сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны тайлангийн боловсруулалт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхой болгох. Тухайлбал, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа, суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг ямар ажлуудыг сайжруулахад чиглэсэн төлөвлөсөн ажлуудыг гаргах, мөн суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, түүний дагуу авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, ахиц дэвшлээ үнэлдэг байх нь хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын нэг үр дүн болно.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Байгууллагын магадлан итгэмжлэлд 3 удаа орсон байна.
- “Үйлдвэрлэлийн дизайн”-ы хөтөлбөр 2019-2024 магадлан итгэмжлэгдсэн.
- “Хувцас дизайн”-ны хөтөлбөр 2021-2026 онд магадлан итгэмжлэгдсэн.

Онцлог зүйл:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч салбар нь олон улсын магадлан итгэмжлэл хийлгэсэн туршлагатай.
- ISO21001:2018 Боловсролын байгууллагын чанарын менежментийн тогтолцоог баталгаажуулсан.
- Сургуулийн хэмжээнд дүрэм журмууд албан бичиг баримтуудыг сайн бүрдүүлсэн.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагаа сул.

Дүгнэлт:

- Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэсэн туршлагатай байгаа нь хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын механизм тогтворжсоныг илэрхийлж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан**Зөвлөмж:**

- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилладаг байх.
- Гадаад, дотоодын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн судалгааг хийдэг байх.
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хийж буй аргачлал, үнэлгээний үзүүлэлтийг тодорхой болгох
- Журмын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээг хийж, үр дүнгээ хэлэлцэж, сайжруулахад анхаарах.
- Суралцагчдыг олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлэх.

Шалгуур 7-ын шинжээчийн багийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	+			
2	Сургалтын үйл ажиллагаа	+			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	+			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	+			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	+			
6	Багшийн үйл ажиллагаа	+			
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	+			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургууль
Хөтөлбөрийн нэр	График дизайн
Хөтөлбөрийн индекс	021106
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийн нийгмийн эрэлт хэрэгцээг гадаад, дотоод ижил мэргэжлийн хөтөлбөрүүдтэй харьцуулсан үр дүнг хэрхэн үнэлж, хөтөлбөрийг өөрчлөн сайжруулсан талаар тайланг бэлтгэдэг байх. Элсэлтийн журмаа шинэчлэн сайжруулахад анхаарч, авьяас чадвартай оюутнуудыг элсүүлэх боломжийг нэмэгдүүлэх. Хөтөлбөрийн зорилгоо ямар үндэслэлээр дэвшүүлсэн, хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлсэн болон батлуулсан талаар баримт бичгийг бэлддэг байх.
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Сургалтын агуулга нь хичээл хоорондын агуулгын давхцал байгаад үнэлгээ дүгнэлт өгдөг байх, мөн суралцагч сонгон судлах боломжийг нэмэгдүүлэх. Сургалтад нэвтрүүлж буй шинэлэг арга, аргачлал нь сургалтын хүрэх үр дүнд ямар үр нөлөөг өгсөнг хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлэн баталгаажуулдаг байх. Үнэлгээний арга, аргачлалын давуу, сул талыг үнэлэн, хөтөлбөрт тохирсон шинэлэг үнэлгээний арга, аргачлалыг хэрхэн нэвтрүүлэх сургалтын бодлоготой байх.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> Сургалтад хэрэглээний болон мэргэжлийн сургалтад чиглэсэн лицензтэй программуудыг ашиглахад анхаарч, сургуулийн жил бүрийн төсөвт санхүүжилтийг суулгаж ажиллах.
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> ҮТС, хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн хувьд богино, дунд, урт хугацааны төлөвлөгөөний дагуу ямар үр дүнд хүрсэн, улмаар өмнөх үзүүлэлтээс хэрхэн ахиц дэвшил гарснаа бодитоор үнэлдэг байх. Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, боловсруулахад нийгмийн болон бусад оролцогч, сонирхогч талуудын оролцоог нэмэгдүүлэх. Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн цахим хуудас ашиглах, вебсайтын мэдээллийн иж бүрэн байдалд анхаарах.
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Гадаад элсэлт зохион байгуулах үе шаттай, цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэн, гадаад оюутны элсэлтийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах. Оюутны сайн дурын клуб, уралдаан тэмцээн, оюутны хөгжилд чиглэсэн үйл ажиллагааны зардал буурсан учир цаашид оюутны үйл ажиллагааг дэмжиж, хэмжээг нэмэгдүүлэх.

	<ul style="list-style-type: none"> • Оюутны сайн дурын ажлыг үнэлэх, урамшуулах тогтолцоог бүрдүүлэн, төгсөгчдөд батламж, тодорхойлолт гаргадаг болох • “Ковид-19” цар тахлаас шалтгаалан тасалдсан оюутны хамтарсан гадаад дадлага, оюутан солилцоог сэргээх.
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Ур чадвартай, мэргэжлийн багшийн нөөцөө тогтвортой байлгах бодлоготой байх. • Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс материаллаг орчны нөхцөл байдлыг сайжруулахад анхаарах. • Багш солилцооны хөтөлбөрийг эрчимжүүлэх, багшийн хөгжил, мэдлэг, ур чадварыг ахиулах туршлага солилцоо гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлэх. • Багш нарыг мэргэжлийн уралдаан тэмцээнд ороход нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжийг бий болгох. • Багш нарын заах арга зүйн чадамжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа, бодлогыг сургуулийн стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> • Бүрэлдэхүүн сургуулийн чанарын менежерийн ажлын төлөвлөгөөг сургуулийн дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөө, чанарын нэгдсэн баталгаажуулалтын журамд уялдуулан гаргах. • Мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах.

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн Технологийн сургуулийн “График дизайн” 021106 бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/М.Моломжамц/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Б.Оюунсүрэн/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../М.Амартүвшин/

IV.Ярилцлагад оролцогчдын нэрс

✓ Оюутны төлөөлөл

№	Овог нэр	Курс	Сонгосон байдал	Утасны дугаар, мэйл хаяг
1	Ц.АНУДАРЬ	2 КҮРС	Оюутны байранд амьдардаг	94225489

2	Ц.УЯНГА	2 КҮРС	Оюутны байранд амьдардаг	95347400
3	З.МӨНХЗАЯА	2 КҮРС	Оюутны байранд амьдардаг	99358885
4	Ү.НЯМЖАРГАЛ	2 КҮРС	Орон нутгийн оюутан	89294149
5	Ц.УЯНГА	2 КҮРС	Орон нутгийн оюутан	95347400
6	Г.ДӨЛГӨӨНТУЯА	3 КҮРС	Орон нутгийн оюутан	89862423
7	Г.БАЯРТӨГС	3 КҮРС	Орон нутгийн оюутан	96333038
8	О.ТЭМҮҮЛЭН	2 КҮРС	Оюутны сайн дурын байгууллагын гишүүн	86679464
9	Н.АРИУНБОЛД	4 КҮРС	Голч дүн 1,2,3,4 күрс	89989599
10	А.НАМУУН	4 КҮРС	Голч дүн 1,2,3,4 күрс	99252322
11	Б.ЭРХЭМ	4 КҮРС	Голч дүн 1,2,3,4 күрс	86816931
12	Т.АМГАЛАНБИЛЭГ	4 КҮРС	Голч дүн 1,2,3,4 күрс	89290080
13	Б.ТЭРГЭЛ	3 КҮРС	Голч дүн 1,2,3,4 күрс	99621819
14	Б.БАЯРЦЭЦЭГ	3 КҮРС	Голч дүн 1,2,3,4 күрс	99529259
15	Б.ОЮУ-ЭРДЭНЭ	3 КҮРС	Голч дүн 1,2,3,4 күрс	94152275
16	Б.АНХБАЯР	3 КҮРС	Голч дүн 1,2,3,4 күрс	86861191
17	П.САНЧИРМАА	2 КҮРС	Голч дүн 1,2,3,4 күрс	88560219
18	О.ЭНХБААТАР	2 КҮРС	Голч дүн 1,2,3,4 күрс	90803787
19	С.ЭМҮЖИН	2 КҮРС	Голч дүн 1,2,3,4 күрс	93270914
20	Г.ХУЛАН	1 КҮРС	Голч дүн 1,2,3,4 күрс	99870789
21	Г.ГАНТУЛГА	1 КҮРС	Голч дүн 1,2,3,4 күрс	91176161

✓ Ажил олгогчдын төлөөлөл

№	Овог нэр	Албан тушаал	Байгууллага	Утасны дугаар, мэйл хаяг
1	Б.ОЧИРВААНЧИГ	Байгууллагын харилцааны дотоод харилцааны хариуцсан менежер	АПУ ХК	86088158
2	А.ГАНТУЛГА	захирал	TBSM ХХК	99057125
3	Э.АРИУНБОЛД	Гүйцэтгэх захирал	АРТЕСН ХХК	99870725
4	Б.ЭНХ-АМГАЛАН	Менежер	MOBICOM	99081083
5	Б.ЭНХТҮВШИН	Байгуулга хариуцсан захирал	UNITEL	88885335
6	Л.СОДБАЯР	Дизайнер	MSM food	91142414

✓ Төгсөгчдийн төлөөлөл

№	Овог нэр	Төгссөн он	Албан тушаал	Байгууллага	Утасны дугаар, мэйл хаяг
1	Б.ДЭЛГЭРМАА	2021	ГРАФИК ДИЗАЙНЕР	CENTRAL TV	Deegii.deeg33@gmail.com 95830112

2	Б.Ангирмаа	2020	ГРАФИК ДИЗАЙНЕР	Monlogistics Holding ХХК	Maarig0105@gmail.com 99120386
3	Б.Ариунболд	2018	мэргэжилтэн	ШУТИС, Нээлттэй боловсролын төв	Asoj60@gmail.com 90202526
4	Б.Төгөлдөр	2020	мэргэжилтэн	ШУТИС, Нээлттэй боловсролын төв	Swordkirit088@gmail.com 88998838
5	С.Баасансүрэн	2020	дизайнер	Trimon studio	Baasansuren.trimon@gmail.com 85304241
6	Б.Батзавьяа	2015	дизайнер	Mongol content	batzaviya@gmail.com 99150772
7	А.Билэгжаргал	2015	артист	Mongol content	bilgeeca@gmail.com 99252616
8	Г.Жавхлан	2022	дизайнер	Happy Messy LLC	jeckobbb@gmail.com 80510720
9	Б.Билгүүнзаяа	2022	Lead product designer	Procraft agency	Uunza48@gmail.com 94352439
10	Г. Идэр	2021	дизайнер	A plus ХХК	Ider.gerelt@gmail.com 88649554
11	Т. Цэвэгням	2021	дизайнер	Мобиком корпораци, маркетингийн алба,	Tuultsevegnyam36@gmail.com 99542662

✓ **Багш нар**

№	Овог нэр	Албан тушаал	Заадаг хичээл	Мэргэжил	Эрдмийн зэрэг цол	Ажилл асан жил	Мэйл хаяг
1	Б.Сэргэл эн	Дэд профессор	Монголын урлагийн түүх онол, Дизайны түүх онол, урлагийн түүх, Урлагийн гоо зүй	Урлаг судлаач	Доктор	20	b.sergelen@must. edu.mn
2	С.Өлзий маа	багш	Үсгийн урлаг, график дизайны уран сайхны шийдэл, Зохиомж 1,2	Хэвлэлийн график дизайнер	Магистр	13	ulziimaa.s@must. edu.mn
3	Г.Халиун	багш	Веб дизайн 1,2, График дизайны програм хангамж, Загварчилал, Дижитал график	График дизайнер	Магистр	6	gkhaliun@must.e du.mn

4	Д.Түмэн болд	профессор	Мэргэжлийн удиртгал, Концепц шинэ санаа, Кино найруулга зүй	Текстилийн инженер, Хувцасны загвар зохион бүтээгч	Доктор	24	tumenbold@must.edu.mn
5	Б.Мэндсайхан	Ахлах багш	Веб дизайн, Анимацийн төсөл, 3D моделийн төсөл	График дизайнер	Магистр	20	bmendsaikhan@must.edu.mn
6	О.Гантулга	багш	Дүрийн шийдэл, Орчны дизайн, Хөдөлгөөнт график 1,2, Дижитал график 1,2	Компьютер график дизайнер	Магистр	14	o.gantulga@must.edu.mn
7	Б.Мөнхзул	Ахлах багш	Алгоритм, Загварчилал, Эдэлхүүний CAD CAM-1,2, Эдэлхүүний CAE	Компьютер Техник хангамж	Магистр	24	zulaa@must.edu.mn
8	А.Цэрэнд улам	багш	3D модель-1,2, 3D анимаци, Дижитал баримал	Компьютер график дизайнер	магистр	11	tserendulam@must.edu.mn
9	М.Номин	багш	Хөдөлгөөнт график-1,2, Зохиомж-1,2, Дижитал график-1,2	График дизайнер	магистр	6	mnomin@must.edu.mn
	Б.Отгончимэг	Ахлах багш	Загварчилал, Алгоритм, Коммуникацийн дизайн, дисплей дизайн	Математик	магистр	29	otgontsimeg@must.edu.mn

V.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

